Стандарт код гэдэг нь Үдсэний статистикын хорооноос батлан гаргасан бүтээгдэхүүн үйлчилгээг ангилсан олон улсад хэрэглэгддэг барааны зориулалт хийгдсэн материал зэргийг үндэслэн ангилсан ангилалын код юм. Энэхүү ангилалын дагуу тухайн бараа үйлчилгээ нь ямар төрлийн бараа үйлчилгээ болохыг мэдэх боломжтой. Иймд та өөрийн дэлгүүрт худалдаалагдаж байгаа бараанд дотоод код буюу стандарт бус код /таны өөрийн зохион хэрэглэж байгаа код/ хэрэглэж байгаа бол энэхүү Стандарт кодыг ашиглах шаардлагатай болно. Жишээ нь та төмс худалдаалж байгаа гэж үзье. Тухайн төмсийг кассаар борлуулахын тулд 4002 гэсэн кодоор кодлон борлуулж байгаа. Учир нь тухайн бараа нь үйлдвэрийн код байхгүй. 4002 гэсэн код бол та энэ барааг худалдах болон тухайн барааны мэдээллийг шалгахын тулд программаас хайж олох код юм. Энэ кодыг та өөрөө зохиож өгсөн. Энэ код бол зөвхөн танай дэлгүүрт хамаатай код. Өөр дэлгүүрт Төмсийг мөн өөр кодоор кодлосон байгаа. Ийм учираас тухайн барааг бүх газар Төмс гэж танихын тулд стандарт ангилалын кодыг сонгож өгөх шаардлага гарч байна. Програм дээр стандарт ангилалын кодыг сонгохдоо **Бүртгэл -> Бараа бүртгэх** цонхыг нээнэ.

Бараа материалын бүртгэл цонхноос тухайн барааг хайж олоод сонгоно.



Тухайн барааны мэдээлэл бараа бүртгэх талбарт гарч ирсэн байна.

Стандарт код нүдний ард байрах томруулдаг шилний зурагтай товчлуур дээр дарахад бүтээндэхүүн үйлчилгээний ангалалууд бүхий цонх нээгдэнэ.







Эхний цонхноос хамгийн ерөнхий ангилалыг сонгоно

**0 хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын бүтээгдэхүүн**

дараагийн цонхноос дэд ангилалыг сонгоно

## 01 хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн

түүний дараагийн цонхноос мөн дараагийн дэд ангилалыг сонгох гэх мэтчилэн тухайн бараа агуулагдах ангилалыг сонгож өгнө.




Төмсний хувьд стандарт ангилалын код нь **0151000** гэсэн кодыг сонгож өгнө. Тухайн кодыг сонгоод 

товчыг дарснаар тухайн код сонгогдоно.

Стандарт код талбарт стандарт кодыг бичихгүй зөвхөн Стандарт ангилалын кодоос сонгож өгөхийг анхаарна уу.

Ийнхүү стандарт кодыг сонгож өгснөөр тухайн барааны мэдээллийг засварлах боломжтой болно.